



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1.</b>							
<b>Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг Дэлхийн геодезийн сүлжээний 2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.</b>							
1.1.1	Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний зураглал	Орон нутгийн төсөв	Төсвийн тооцоо-1	Засгийн газрын 267-р тогтоол	1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг TRF2020 эринд шилжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, төсвийн тооцоог гаргаж, 2023 оны төсөвт тусгуулахаар Засаг даргад хүргүүлсэн байна.		
1.1.1.1	Том масштабын байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний зураглалыг шалгаж хүлээн авах	Орон нутгийн төсөв	2 сумын зураглалын ажлын даалгавар, зураглал	21 аймаг, 330 сум, 45 суурин газарт зохиогдсон 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг 2013-2017 онд зурагласан.	<b>Эхний хагас жилд:</b> 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх Ажлын даалгавар хамтран боловсруулж, батлан сумдад хүргүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийг шалгаж, хүлээн авсан байна.	2024 оны орон нутгийн төсөвт Ханбогд, Цогтцэций, Гурвантэс, Даланзадгад сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 эринд шилжүүлэх ажлын төсвийг нийт 4 сумын хэмжээнд 890 сая төгрөгийг батлуулан төндрийн ажил зарлагдаж ӨМАХААГ/20240101635 гэрээний дугаартай гэрээг байгуулан, гүйцэтгэгч байгууллагаар "Агар од" ХХК шалгаран түншлэгч байгууллага "Кадсүрвэй" ХХК хамтран дээрх ажлыг хийж гүйцэтгэж 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр суурин болон хээрийн судалгааны,	

						тайланг ирүүлэн хянуулсан,. Ажлын явцад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан. Тухайн ажлын гүйцэтгэлийг Геодези зураг зүйн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн байна.	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2.</b>							
<b>Навигацийн хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.</b>							
1.2.1	GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	1.Байнгын ажиллагаатай станц-43 Бодит агшны хяналтын хэмжилт - 4	2013-2017 онд Улсын төсвөөр 38, УБ хотын төсвөөр 5 станц суурилуулсан. 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.	43 Байнгын ажиллагаатай станцыг нэгдсэн сүлжээнд холбогдож, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд алдаагүй зөв хэмжилт хийх боломж бүрдсэн байна.		
1.2.1.1	GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах	Үйл ажиллагаа	Байнгын ажиллагаатай станцын тоо	2013-2017 онд Улсын төсвөөр 38, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан. 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна.	Өмнөговь аймаг, Ханбогд, Даланзадгад, Цогтцэций сумын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг 1-12 сарын хугацаанд тогтмол ханган ажиллаж байна. Гарсан доголдолыг цаг алдалгүй явж хэвийн үйл ажиллагаанд оруулж ажилласан.	
1.2.1.2	Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр хяналт тавих	Үйл ажиллагаа	Бодит агшны хяналтын хэмжилт - 4	2020 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжийг шинэчилж, хэрэглээнд нэвтрүүлсэн.	Аймгийн төвд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилт хийж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Өмнөговь аймгийн хэмжээнд байгаа OMA-1, OMA-2, OMA-3 GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр улирал тутамд очиж хяналт шалгалтын хэмжилтийн хийж гүйцэтгэн 4 удаагийн хэмжилтийн датаг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газарт хүргүүлж мөн <a href="#">192.168.20.24</a> фолдерт хуулан байршуулсан.	

Стратеги төлөвлөгөөний зорилго 1.4. Монгол улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.							
1.4.1	Монгол орны өндрийн I ангийн сүлжээ	Улсын төсөв Үйл ажиллагаа	Өндрийн I ангийн сүлжээний 1 шугам	2 полигон 7 шугамтай өндрийн I ангийн сүлжээний хэмжилтийг 2014-2021 онд гүйцэтгэсэн.	Өндрийн I ангийн 1 полигон, 4 шугамын өгөгдлийг тэгшитгэн бодож, сүлжээний каталоги батлуулсан байна.		
1.4.1.1	Монгол Улсын гравиметрийн сүлжээний цэгт абсолют гравиметрийн хэмжилт хийх	Улсын төсөв	Абсолют гравиметрийн хэмжилт - 1 цэг	Цар тахлын улмаас хэмжилтийг 2022 оны 6-р сард хийхээр Японы талтай тохирсон. Гравиметрийн 1-р ангийн сүлжээний 5 цэгийн хайгуул, судалгааг 2019-2020 онд хийсэн.	Жилийн эцэст: Абсолют гравиметрийн хэмжилт хийх нөхцлийг бүрдүүлж, хамтран ажилласан байна.	Монгол Улсын гравиметрийн сүлжээний эхлэл цэг болон тулгуур сүлжээний цэгүүд дээрх абсолют гравиметрийн Монгол-Японы хамтарсан судалгааны хэмжилт 9 сарын 7-ны өдрөөс 9 сарын 13-ны өдрийн хооронд 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Даланзадгад сум, Шүүхийн тамгын газрын барилгын В1 давхарт байрлах 0017 цэгийн дугаартай гравиметрийн тулгуур сүлжээний цэг дээр абсолют гравиметрийн судалгааны хэмжилтийг тасралтгүй 117 цагийн турш хийж, мөн Даланзадга сум, Шинэ суурьшлын бүс, Монгол банкны барилгын зүүн хойно байрлах 0011 цэгийн дугаартай гравиметрийн цэг дээр харьцангуй хэмжилтийн ажлыг хийж зохион байгуулан ажилласан.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7. Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.							
1.7.1	Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Мониторингийн 350 цэг	2021 онд мониторингийн сүлжээгээр байгуулсан 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийгдсэн.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний 1100 цэгээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бусад байгууллагууд ашиглах нөхцөл боломжоор хангагдсан байна.		
1.7.1.2	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх	Үйл ажиллагаа	1 судалгаа	-	Сум болон холбогдох байгууллагаас газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн газрын байршил,	Аймгийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийгдсэн болон хийлгэх шаардлагатай газруудын судалгааг гаргаж ГХБХБГ-ын	

	судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх				хугацааны талаарх судалгааг авч нэгтгэнэ. Тус судалгаанд дүн шинжилгээ хийж газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ.	даргын 2024 оны 263 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	
1.7.2	<b>Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих</b>	<b>Орон нутгийн төсөв</b>	<b>Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо</b>	<b>Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө батлагдсан.</b>	<b>Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.</b>		
1.7.2.1	Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршлыг гаргаж, нөхөн сэргээх байршил, талбайн хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагаа	1 төлөвлөгөө	-	<b>Эхний хагас жилд:</b> Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр хохирол учирсан, доройтолд өртсөн талбайн байршлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хэмжээнд боловсруулж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр хохирол учирсан, доройтолд өртсөн талбайн байршлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээтэй төлөвлөн Газрын удирдлагын хэлтсийн даргаар батлуулж ГХБХБГ-ын 2024 оны 264 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.Аймгийн хэмжээнд доройтол өртсөн 27 га газрыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 542,388,642 төгрөгний нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	
1.7.2.2	Аймгийн хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлуудын тайлан, тоон мэдээллийг	Үйл ажиллагаа	Цахим системд оруулсан тоон мэдээлэл	-	<b>Эхний хагас жилд:</b> Газрын мониторингийн цахим системд ороогүй 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын	Өмнөговь аймгийн хэмжээнд хот тосгон бусад суурин газрын төлөв байдал чанарын төлөвлөгөөт хянан баталгаа нь 2010, 2019 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн байдаг. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас судалгаа ирүүлэх	

	нэгтгэж, Газрын мониторингийн цахим системд оруулах				захиалгат хянан баталгааны тайлан, тоон мэдээллийг стандартын дагуу нэгтгэж мэдээллийн санг бий болгосон байна.	тухай албан бичгийн дагуу 2010, 2019 онуудад хийгдсэн ажлын тайлан, тоон мэдээллийг нэгтгэн ГХБХБГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 264 тоот албан бичиг болон ГХГЗЗЕГ-ын Газрын мониторингийн хэлтсийн мэргэжилтэнд цахим хаягаар хүргүүлсэн.	
1.7.2.3	Газар хамгаалах, нөхөн сэргээх зардлын зах зээлийн үнийн судалгаа хийх	Үйл ажиллагаа	Судалгаа-1	-	<b>Эхний хагас жилд:</b> Газрын нөхөн сэргээлтийн ажлын үе шатыг нарийвчлан тодорхойлж, нөхөн сэргээлт хийгдэхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулж, задаргааг тооцсон судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	2023 онд газар хамгаалсан, нөхөн сэргээсэн жилийн эцсийн байдлаарх мэдээ болон 2024 онд газар нөхөн сэргээхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулан судалгаа гаргаж ГХБХБГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 268 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	
<b>1.7.3</b>	<b>Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх</b>	<b>Урсгал төсөв</b>	<b>Суурь зургууд гарсан байна.</b>	<b>2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.</b>	<b>Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглах нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.</b>		
1.7.3.1	Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох	Үйл ажиллагаа	Ирүүлсэн тайлангийн тоо	БХБС-ын 2022 оны 126 дугаар тушаалаар "Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар" батлагдсан.	<b>Жилийн эцэст:</b> Газрын даамал, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн сум тус бүрээр ургамлын бүрхэвчийн зураглалыг хийж, бэлчээрийн газрын биомасс, даацыг тооцон аймгийн хэмжээнд элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газрыг тодорхойлж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, эвдрэл, бэлчээрийн даац, чадавхийг тодорхойлон боловсруулалт хийж тайланг ГХБХБГ-ын даргын 2024 оны 11 сарын 07-ны өдрийн 476 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ газарт хүргүүлсэн.	

**Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.**

Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.

1.8.1	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Улсын хэмжээний тайлан	2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулсан.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцыг жил бүр Засгийн газарт танилцуулсан байна.		
1.8.1.1	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн тайлан-1	Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг 1-р улиралд багтаан гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гарган 2024 оны 01 сарын 15-ний өдөр ГЗБГЗЗЕГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Gereltuya.g@gazar.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.	
1.8.2	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Орон нутгийн төсөв	7 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.		
1.8.2.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Дүгнэлтийн тоо	Өмнөговь	<p><b>Эхний хагас жилд:</b></p> <p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах үе шатуудад хяналт тавьж, үе шатны тайлангуудад дүгнэлт гарган гүйцэтгэгчид болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b></p> <p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн, зөв</p>	2024 оны эхний хагас жилийн байдлаар Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн тодотгох ажлыг гүйцэтгэж буй Инженер геодези ХХК хээрийн судалгааны ажлаар 15 сумдаар тойрч ажиллаж, төлөвлөлтийн төслийн ажлын тайланг 15 сумдын удирдлагуудад, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ын холбогдох мэргэжилтэн нарт, 18-ны өдөр Даланзадгад сумын удирдлагуудад танилцуулж санал авч ажилласан. Аймгийн ГХБХБГ явцын хяналтыг тогтмол хийж төлөвлөгөөний төсөлд 4-5 удаа санал өгч Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шинэчлэн тодотгол хийх ажлыг "Инженер геодези" ХХК нь хийж гүйцэтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 19 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж 2024	

					зурагласан эсэхэд хяналт тавьсан байна.  ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна.	оны 19/25 дугаар тогтоолоор хүлээлгэн өгсөн.	
1.8.3	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих	Үйл ажиллагаа	8 аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.	Шинэчлэн боловсруулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аймгуудад хүргүүлсэн байна.		
1.8.3.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	Үйл ажиллагаа	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Өмнөговь	<b>Эхний хагас жилд:</b> Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. <b>Жилийн эцэст:</b> Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. Хэрэгжилтийг 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнасан байна.	Аймгийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 15/03 дугаар тогтоолоор 20 нэгж талбарт 1098,52га газрыг олгохоор төлөвлөснөөс МУ-ын Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолоор 10 нэгж талбарт 60,8га газрыг олгохоор батлагдсан. Үүнээс 3 нэгж талбар бүхий 3,24га газрыг ногоон байгууламжийн зориулалтаар нийтийн эдэлбэр газарт авахаар нэгж талбарт 7 нэгж талбарт 57,6га газрыг төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан өргөдлийн дагуу олгосон байна. 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголыг хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 17/05 дугаар тогтоолоор 13 нэгж талбарт 738,9га газрыг олгохоор төлөвлөснөөс МУ-ын Засгийн газрын 2024 оны 74 дугаар тогтоолоор 8 нэгж талбарт 736,13га газрыг олгохоор батлагдсан. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор 2024 оны газар зохион	

						байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн 1 нэгж талбар бүхий 730,59га газрыг нийтийн эзэмшлийн сул чөлөөтэй газрын зориулалтаар, 1 нэгж талбарт 1,94га газрыг үйлдвэрийн зориулалтаар дуудлага худалдаагаар, 6 нэгж талбарт 3,6га газрыг төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд өргөдлийн дагуу олголоо.	
1.8.3.2	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээ, судалгааг холбогдох байгууллагад хүргүүлэх	Үйл ажиллагаа	Судалгаа, мэдээллийн тоо	18 аймгийн ГЗБЕТ 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлыг гүйцэтгэсэн Инженер геодези ХХК-д 2024-2029 онд хийгдэх бүтээн байгуулалтын төслүүдийн талаарх мэдээллийг АЗДТГ-аас авч хүргүүлсэн. Өмнөговь аймгийн сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа Сонголт дизайн ХХК-д Булган, Ноён, Номгон сумдын өмнө нь хийгдэж байсан инженер геологийн судалгааг хүргүүллээ. Гурвантэс сумын Шивээ хүрэн боомтын ерөнхий төлөвлөгөөг хийж байгаа Нарт дизайн ХХК-ны хүсэлтийн дагуу аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, Газрын нэгдмэл сангийн тайлан, хилийн боомтын орчмын газар эзэмшигч, иргэн хуулийн этгээдийн мэдээллийг хүргүүллээ.	
1.8.4	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Орон нутгийн төсөв	16 сум	98 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулсан.	Жил бүр 18 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.		
1.8.4.1	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах.	Үйл ажиллагаа	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан.	<b>Эхний хагас жилд:</b> Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. <b>Жилийн эцэст:</b>	Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д тухайн бүр загварын дагуу гаргаж байршуулан ажиллах чиглэлийг ГХБХБГ-ын даргын 2024 оны 128 тоот албан бичгээр сумдын газрын даамлуудад хүргүүлэн хэрэгжилтийг цахим системд оруулж байна.	

					Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж, цахим системд байршуулсан байна. Хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард багтаан тайлагнасан байна.	
1.8.4.2	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг зохион байгуулах	Үйл ажилл агаа	Санхүүжилт ын хэмжээ	-	<b>Эхний хагас жилд:</b> Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгуулах талаарх санал болон танилцуулгыг холбогдох албан тушаалтанд танилцуулах ажлыг зохион байгуулсан байна.  <b>Жилийн эцэст:</b> Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг 2025 оны төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулж, батлуулсан байна.	Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн хийх шаардлагатай 2024 онд хугацаа дуусаж байгаа Гурвантэс сум, 2025 онд хугацаа дуусах Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо сумдын Засаг дарга нарт болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг даргад 2025 онд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулан холбогдох зардалыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийх чиглэлийг ГХБХБГ-ын даргын 2024 оны 218 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2025 онд Өмнөговь аймгийг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөнд дээрх 4 сумын төлөвлөгөөг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэхээр 580,0 төгрөгийг тооцож тусгуулах саналыг ГХБХБГ-ын даргын 2024 оны 452 тоот албан бичгээр АЗДТГазарт хүргүүлэн Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгууллаа
1.8.4.3	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажилла гаа	Дүгнэлтийн тоо	Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан.	<b>Эхний хагас жилд:</b> Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, хянуулан батлуулсан байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, үе шат бүр дээр дүгнэлт	2024 онд Гурвантэс, 2025 онд Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Засгийн газрын 2023 оны 50 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангаж сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг 2025 оны орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхээр сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлэн ажилласан.

					гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.		
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.13.</b>							
<b>Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих</b>							
1.13.2	Салбарын үйл ажиллагаанд цахим гарын үсэг болон тоон гарын үсэг нэвтрүүлэх	Үйл ажиллагаа	85 тоон гарын үсэг	Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон.	Газрын харилцааны салбарын нийт албан хаагчид тоон гарын үсэг ашигладаг болсон байна.		
1.13.2.1	Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэвтрүүлэх	Үйл ажиллагаа	- Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо	Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон.	- Тоон гарын үсгийн олголтыг шинэчлэн хийсэн байна. - Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын тоон гарын үсэг эзэмшдэг эсэх талаар судалгааг авч, 2 тоон гарын үсэг шинээр ашиглаж эхэлсэн. Аймгийн улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран байгууллагын албан хаагчдын тоот гарын үсгийг баталгаажуулах ажлыг байгууллага дээрээ зохион байгуулсан	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14.</b>							
<b>Төрийн архивын стандарт орчныг сайжруулах</b>							
1.14.1	Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх	Үйл ажиллагаа	1764 хадгаламжийн нэгж	2022 онд Төрийн архивын 14879 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбосон.	1764 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбоно.		
1.14.1.1	Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх	Үйл ажиллагаа	Цахимжуулсан хадгаламжийн нэгжийн тоо	2023 оны байдлаар 60 хадгаламжийн нэгжийн 12,500 хуудас баримт цахимжсан.	<b>Эхний хагас жилд:</b> 20 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй	60 хадгаламжийн нэгж, 13000 хуудас баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.	

					хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна. <b>Жилийн эцэст:</b> 40 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад		
					ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.		

**Стратеги төлөвлөгөөний зорилго 1.15.  
Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах**

1.15.1	Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан ажлын тоо	-	Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.			
1.15.1.1	Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах, хяналт тавих, Нууц албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	1 мэдээ, 1 тооллого	2023 онд Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр явуулсан үйл ажиллагааны мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 2023 онд Төрийн болон албаны нууцын тооллого хийж, дүн мэдээг хугацаанд нь явуулсан.	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, мэдээ тайланг ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн байна. Тооллогын мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	2024 оны 05 сарын 15-ны өдөр Тагнуулын ерөнхий газрын Өмнөговь аймаг дахь газраас зохион байгуулсан Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх сургалт, мэдээллийн ажил гэх 1 өдрийн сургалтанд хамрагдан ажилласан. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, бусад журам, тогтоолын кэрэгжилтийн хангах, зөрчил дутагдлыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх төрийн болон албаны нууцыг хамгаалах арга хэмжээний шалгалтанд хамрагдан Төрийн болон албаны нууц хадгалалт хамгаалалтын талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу ажил үүргийг гүйцэтгэн ажилласан. Зөвлөмжийн дагуу “Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын төрийн болон албаны нууцыг гамшгаас хамгаалах төлөвлөгөө”, Төрийн нууцад хамаарах мэдээлэлд кийсэн тооллого”, “Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан гушаалтны жагсаалт, “Төрийн болон		

						албаны нууцад хамаарах мэдээллийн кагсаалт"-ийг тус тус батлан, тооллогын мэдээ тайланг Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 352 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.20.</b>							
<b>Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.</b>							
1.20.1	Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх	Үйл ажиллагаа	Инженерийн дэд бүтцийн мэдээлэл	-	Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна.		
1.20.1.1	Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний орон зайн тоон зургийг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран баяжилт хийх, мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Төлөвлөлтийн 7 давхаргын мэдээлэл	-	Аймгийн хэмжээнд Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн давхаргын мэдээллийг бүртгэсэн байна.	Хот байгуулалтын цахим системийн баяжуулалтыг хийхээр цаасан бүрдүүлэлт, барилгуудын мэдээллийг системд оруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Шинэчлэгдсэн системд 2024 онд шинээр ашиглалтад орсон 67 барилга байгууламжийн мэдээлэл оруулж, 2023 онд ашиглалтад орсон 157 барилгын мэдээллийг мөн шинээр оруулан ажиллаж байна.	
1.20.2	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг танилцуулах, сурталчилах	Үйл ажиллагаа	2 арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг сурталчилсан байна.		
1.20.2.1	Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчилах	Үйл ажиллагаа	4 арга хэмжээ	-	<b>Эхний хагас жилд:</b> Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион	Архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг хот байгуулалтын цахим системээр илгээх заавар танилцуулгыг Өмнөговь аймгийн ГХБХБГ-ын фейсбүүк сувгаар дамжуулан сурталчлан ажиллаж байна.	

					байгуулж, хэрэгжүүлсэн байна.	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.21.</b> <b>Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.</b>						
<b>1.21.1</b>	<b>Аймгийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх</b>	<b>Үйл ажиллагаа</b>	<b>Хэрэгжилтийн хувь</b>	<b>-</b>	<b>Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.</b>	
1.21.1.1	Аймгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 13 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Үйл ажиллагаа	Шалгалт хийсэн гүйцэтгэлийн хувь,	- Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 576 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр "Хяналт шалгалтын төлөвлөгөөг" Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлуулсан. - Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар батлуулсан.	Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Барилга хот байгуулалтын яамны салбарын хяналтын газраас 18, ГЗБГЗЗЕГ-аас 16, нийт 34 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийгдэхээр зарлагдсанаас жилийн эцсийн байдлаар Барилгын техникийн чиглэлээр 10, Газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр 16 объектод төлөвлөөт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. ГЗБГЗЗЕГ-ын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалж 2024 онд 2024 оны 04 дүгээр сараас батлагдсан, мөн Газар геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч Э.Ариунтулга нь өөр ажилд шилжсэнтэй холбоотойгоор тухайн онд Газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр шалгалтад хамрагдахаар зарлагдсан 16 объект /1 сумын Засаг дарга, газрын даамлын газар олголт/-д төлөвлөгөөт шалгалт хийхээр төлөвлөснөөс 2 аж ахуйн нэгж /Говь хармагтай, Ёл цамхаг ХХК/-ийн үйл ажиллагаа зогссон, 1 сумын газрын даамлын газар олголтын үйл ажиллагааг 2023, 2024 онд ерөнхий газраас бусад байгууллагатай хамтран шалгасан байх ба 13 объектын үйл ажиллагаанд 35.2 кодтой Хот тосгон, бусад суурин газарт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шалгах хяналтын хуудсаар хяналт шалгалт хийж эрсдэлийг үнэлэхэд 2 буюу 15.4 хувь нь "бага эрсдэлтэй", 7 буюу 53.8 хувь нь "дунд эрсдэлтэй", 4 буюу 30.8 хувь нь их эрсдэлтэй шалгагдсан ба нийт эрсдэл үүсэх магадлал 41.5 хувьтай үнэлэгдлээ.

						<p>-Газар, геодези зураг зүйн хяналт шалгалт хийхээр зарлагдсан 13 объектод шалгалт хийж, нийт 324 зөрчил илрүүлснээс 178 зөрчлийг буюу 55%-ийг арилгуулж ажилласан ба 10 аж ахуйн нэгжид 67 заалт бүхий 10 албан шаардлага /02-27-04/088/01, 02-27-04/088/03, 02-27-04/088/05-07, 35-27-01/037/15-18, 35-27-01/037/21/, 6 аж ахуйн нэгжид 57000000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, бүрэн барагдуулсан. Байгууллагын зүгээс унаа, томилолтын зардал шийдвэрлэж өгөөгүйгээс шалтгаалж шалгалтын ажил хойшлогдсонтой холбоотойгоор албан шаардлагын хэрэгжилт 50 хувьтай байна. Мөн Хар алтан уул ХХК, Урчуул-Отог ХХК, Эс Эм Эс Ти ХХК-д зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.-Барилгын техникийн хяналтын чиглэлээр Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан "Хүннүгийн говь" ХХК-ийн гүйцэтгэж буй "1200 хүүхдийн сургуулийн барилга, "Тэлмүүн доной" ХХК-ийн гүйцэтгэж буй "Төв номын сангийн барилга", "Эрхэст баян говь" ХХК-ийн гүйцэтгэж буй Даланзадгад сумын 8-р баг "Нанзад хотхоны дахин төлөвлөлтийн орон сууцны барилга", "Тост говь" ХХК-ийн гүйцэтгэсэн Цогтэций сумын Цагаан Овоо багийн төвийн барилга, "Хос цамхаг өргөө" ХХК-ийн Даланзадгад сумын 3-р баг, "Нийтийн орон сууцны барилга", "Тотал-Идеал" ХХК-ийн гүйцэтгэсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Жаргалан тувийн барилга", "Хөх бүрдний эх" ХХК-ийн гүйцэтгэсэн "Сэргээн засах 40 ортой уламжлалын эмнэлгийн барилга", "Язгууртны говь" ХХК-ийн гүйцэтгэсэн Даланзадгад сумын 3-р баг, 40 ортой нийтийн орон сууцны 2 блок барилга, "Этүгэн жим" ХХК-ийн гүйцэтгэсэн Даланзадгад сумын "Дата төв"-ийн барилгуудын угсралтын ажилд 02.1.2. кодтой Каркасан болон бүрэн цутгамал барилгын угсралтын ажлыг шалгах хяналтын хуудасаар тус тус эрсдэлийн үнэлгээ хийлээ. Дээрх объектуудад хяналтын хуудсаар төлөвлөгөөт шалгалт хийхэд хууль</p>
--	--	--	--	--	--	---

						сахин мөрдөлт 85.8, эрсдэл үүсэх магадлал 15.3 хувьтай үнэлэгдсэн байна. -Өргөх байгууламжийн чиглэлээр Улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/01 тоот албан даалгаварын дагуу Өмнөговь аймагт ашиглагдаж байгаа 15 лифтэд бүрэн бүтэн байдал, техникийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хяналт шалгалт хийж ажиллаа.
1.21.1.2	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх.	Үйл ажиллагаа	Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь,	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн.	Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Шалгалтын дүнг хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Газрын кадастрын цахим системд Нэгж талбарын хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх шалгалтыг 15 сумын хэмжээнд түүврийн аргаар 170 нэгж талбарыг хамруулан шалгалт хийж, гүйцэтгэсэн ба 78 нэгж талбар буюу 45.9 хувийг алдаатай, буруу бүртгэсэн зөрчил илэрсэн ба шалгалтын үр дүн, шалгалтаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, саналыг шалгалтын танилцуулгад тусган ГЗБГЗЗЕГ-ын Салбарын хяналтын хэлтэст хүргүүлсэн.
1.2.1.3	Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Үйл ажиллагаа	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь,	-	Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Өмнөговь аймгийн хэмжээнд Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг 4 хуулийн этгээд "Гоулден херо" ХХК, "Ти Эйм Эйч сүрвэй" ХХК, "Эрдэнэсцэций сөрвэй" ХХК, "Соолон санчир" ХХК-ийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 11 дүгээр сарын 14-ний өдөр Хяналт шалгалтын хэлтсийн улсын байцаагч Ц.Хандармаатай хамтран шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтын явцад илэрсэн зөрчилгүй бага эрсдэлтэй гарсан. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй 6 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн бөгөөд газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг 35.5 кодтой "Геодези, зураг зүйн үйл

						ажиллагааг шалгах хяналтын хуудсаар <sup>9</sup> эрсдэлийг үнэлэхэд Гоулден херо ХХК-ийн эрсдэл үүсэх магадлал 3.7%, Хасар баян сүрвэй ХХК-ийн эрсдэл үүсэх магадлал 15.3%, Ти Эйм Эйч сүрвэй ХХК-ийн эрсдэл үүсэх магадлал 3.7%, Эрдэнэс цэций сөрвэй ХХК-ийн эрсдэл үүсэх магадлал 4.1%, Соолон санчир ХХК-ийн эрсдэл үүсэх магадлал 15.3%	
						буюу бүгд бага эрсдэлтэй, хууль тогтоомжийн сахин мөрдөлт 91.6%-тай үнэлэгдсэн байна. Шалгалтын явцад нийт 28 зөрчил илрүүлж, 15 зөрчлийг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа ажлын төрлөөр мэргэжлийн байгууллагын эрхтэй Ворлдгоби ХХК-ийг удирдамжид заасан шалгуур үзүүлэлтээр шалгаж, шалгалтын танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлсэн	
1.2.1.4	Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Үйл ажиллагаа	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь,	-	Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд Соёл, урлагийн газрын хяналтын улсын байцаагчтай хамтран Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй соёл урлаг /театр, музей, хүүхдийн ордон, номын сан, соёлын төв/-ийн байгууллагын 18 хуулийн этгээдийн 38 нэгж талбарын 7.7819 га газрын газар ашиглалтын байдал, мөн Монгол улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор тус аймгийн Булган, Ханбогд, Цогт-овоо, Гурвантэс, Манлай, Номгон сумын 6 төрлийн 27 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг улсын хамгаалалтын зэрэглэлд байхаар тогтоосон газарт шалгалт хийж, нийт 118 зөрчил илрүүлэн 48 зөрчлийг буюу 40.7%-ийг арилгуулсан. Ханхонгор, Гурвантэс, Цогт-Овоо сумын соёлын төвийн зөрчлийг арилгуулахаар нийт 15 заалт бүхий 3 албан шаардлага /35-27-01/037/11, 35-27-01/037/12, 35-27-01/037/13/, 14 соёлын байгууллагад 84 заалт бүхий 35-27-01/037/01-14 дугаартай зөвлөмж хүргүүлж ажилласан.	

1.21.1.5	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах	Үйл ажилла гаа	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь,	-	Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, танилцуулгыг Салбарын хяналтын хэлтэст хүргүүлсэн.
1.21.1.6	Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх	Үйл ажилла гаа	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь,	2023 онд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн.	<b>Эхний хагас жилд:</b> Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.	Тайлант хугацаанд 10 сумын газрын даамал, кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн нь өмнөх шалгалтаар илэрсэн алдаатай, буруу бүрдүүлсэн нэгж талбарын хувийн хэргүүдийн зөрчлийг арилгасан гэх тайланг ирүүлсэн. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтийн алдаатай бүртгэгдсэн хувийн хэргүүдийн зөрчлийг арилгасан эсэхэд гүйцэтгэлийн хяналт хийж, газрын даамал, мэргэжилтнүүдээс ирүүлсэн зөрчлийг арилгасан гэх тайлантай тулгаж үзэхэд Хүрмэн, Даланзадгад сум болон кадастрын мэргэжилтнээс бусад сумд зөрчлийг арилгаагүй, зөрчил арилгалт 35 хувьтай шалгагдсан.
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.</b>						
<b>Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.</b>						
1.22.2	<b>Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох</b>	Үйл ажилла гаа	Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт	Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.	Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.	
1.22.2.1	Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх	Үйл ажилла гаа	Санал өгсөн төслийн тоо	2022 онд улсын хэмжээнд 6 норм, дүрэм, 5 стандарт, 12 журам, 3 зааварт санал өгсөн.	Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгсөн байна.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журамд 2023 оны А/133 дугаар тушаалаар оруулсан нэмэлт өөрчлөлтөнд цахим санал асуулгаар ГЗБГЗЗЕГ-ын Кадастрын хэлтэст санал өгч ажилласан.

						Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д “газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмыг батлах” заасныг гэж үндэслэн тус журмын ирүүлсэн төсөлтэй танилцаж ГХБХБГ-ын даргын 2024 оны 247 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. Газрын тухай хуульд 2023 оны 11 сарын 10, 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ГХБХБГ-ын даргын 2023 оны А/199 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг “Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөх олговорын хэмжээг тогтоох, нөхөх олговорыг дүйцүүлэн тооцох журам”-д санал хүргүүлсэн. Газрын тухай хуульд 2023-2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн жагсаалтаас үйл ажиллагаанд хамаарах заалтын хэрэгжилтийг гаргаж ГХБХБГ-ын даргын 2024 оны 511 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Газрын хяналтын байцаагч 2024 онд салбарын 1 журамд 2 санал, ГХБХБЕГ-аас шинэчилж байгаа 6 хяналтын хуудаст 7 санал хүргүүлсэн.
1.22.2.2	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх	Үйл ажиллагаа	Эрсдэлийн үнэлгээг үнэлсэн байдал	2023 онд улсын хэмжээнд 7035 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн.	<b>Жилийн эцэст:</b> Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна.	Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр шилэн хяналтын цахим системд ашиглагдаж байгаа болон шинээр баригдаж байгаа 330 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. Үүнээс Их эрсдэлтэй 14, Дунд эрсдэлтэй 183, Бага эрсдэлтэй 133 объект хамрагдсан байна. Газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр нийт 180 объектын эрсдэлийг үнэлсэн. Үүнээс Их эрсдэлтэй 110, Дунд эрсдэлтэй 58, Бага эрсдэлтэй 12 объект хамрагдсан байна.
1.22.2.3	Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах	Үйл ажиллагаа	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын	Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар 2023 онд улсын	<b>Жилийн эцэст:</b> Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг Засгийн газраар	Их эрсдэлтэй үнэлэгдсэн 13, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2, нийт 15 объектыг 2025 онд төлөвлөгөөт шалгалтад хамруулахаар Ерөнхий газрын Салбарын хяналтын хэлтэст хүргүүлсэн.

			жагсаалтыг батлуулсан байдал	хэмжээнд 367 объектод хяналт шалгалт хийсэн.	батлуулахад санал өгч, ГЗБГЗЗЕГ-тай хамтран ажилласан байна.	
